



**МОНГОЛ УЛСЫН  
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ**

Засгийн газрын XI байр, Самбуугийн гудамж 11,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 33 33,

Цахим шуудан: info@med.gov.mn

2025. 01. 07 № 03/51

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ч.ӨНӨРБАЯР ТАНАА**

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандан ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн 2024 оны жилийн эцсийн тайлан мэдээг хүргүүлж байна.

Хавсралт..... хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



И.БАТХҮҮ

241948

**ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ  
ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН  
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

2025 оны 01 дүгээр  
сарын 07-ны өдөр

Улаанбаатар  
хот

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”, Монгол Улсын Засгийн газрын “Иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 2005 оны 67 дугаар тогтоолын хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яамны **2024 оны жилийн эцсийн байдлаар** иргэдээс төрийн байгууллага болон албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын мэдээ, тайланг нэгтгэн гаргалаа.

Эдийн засаг, хөгжлийн яаманд 2024 онд **52** өргөдөл, гомдол байгууллагын албан хэрэг хөтлөлтийн программд бүртгэгдэж, Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах төв /11-11/-өөр дамжуулан **14** санал, гомдол, **нийт 66** өргөдөл, гомдлыг хүлээн авч ажилласан байна. Үүнээс **59 өргөдөл, гомдлыг** хуулийн хугацаанд шийдвэрлэж, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт зааснаар 30 /гуч/ хоногийн хугацааг хэтрүүлж **нийт 6** өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт **98.4** хувийн үзүүлэлтэй байна. Одоогоор 1 гомдол хуулийн хугацаа хэтэрсэн байна.

Хугацаа хоцорч шийдвэрлэгдсэн өргөдөл, гомдлын тайлбар хугацааны дарааллаар:

1. Хугацаа хэтрүүлсэн гомдлын тайлбар: “Жин и жао” ХХК-ийн Ерөнхий захирал Ц.Ганболд Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2013 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 1068 дугаар шүүхийн шийдвэрээр түүнд Засгийн газрын нөөц хөрөнгөөс 427,494,661 төгрөгийг гаргуулан олгуулахаар шийдвэрлэснийг хүчингүй болгосонд 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01/06 дугаар албан бичгээр гомдол гаргасан. Тус гомдлыг шийдвэрлэх явцад хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны мэдээлэлтэй танилцах, нэмэлт тодруулга авах шаардлагатай болсон. Улмаар Эдийн засаг, хөгжлийн яамны 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 03/445 дугаартай албан бичгээр иргэнд мэдээлэл хүргэж, гомдлыг шийдвэрлэсэн.
2. Хугацаа хэтрүүлсэн гомдлын тайлбар: Иргэн Н.Алтангэрэлээс 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдөр ирүүлсэн Шүүхийн барилга, байгууламж тэдгээрийн нөхцөлийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлэл хүссэн хүсэлт ирүүлсэн. Тус хүсэлт нь Монгол Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний саналыг судалж шийдвэрлэх хугацаанд ирүүлсэн, шүүхийн барилга байгууламжийн ажиллах, нөхцөл боломж шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг цуглуулахад нэмэлт хугацаа шаардлагатай болсон.
3. Хугацаа хэтрүүлсэн гомдлын тайлбар: Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн ХЭГ/339 дугаартай албан бичгээр Канад Улсын иргэн Даниел Бодуэний хувь хүний нууцад хамаарах мэдээллийг Гадаад харилцааны яамны Консулын газрын дэд захирал Ч.Батбилэг бусдад дамжуулсан тухай итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Адъяасүрэнгийн гаргасан гомдлыг ирүүлсэн. Тус хэрэг нь Цагдаагийн газар дээр хянагдаж байгаа бөгөөд ирсэн гомдлыг хэрхэн шийдвэрлэх талаар судалгаа хийж, удирдлагатай зөвшилцөхөд хугацаа шаардагдсан болно.
4. Хугацаа хэтрүүлсэн гомдлын тайлбар: БНХАУ-ын иргэн И.Цогт /Chaoketu/ 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр “ЭБНЭ” ХХК-ийн хувьцаа эзэмшигч бөгөөд гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Д.Эрдэнийн залилангийн хэргийг мөрдөн шалгах ажиллагаа удаашралтай байгаа болон Ашигт малтмалын тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчээр бүртгээгүй байгаа тухай гомдлыг ирүүлсэн. Тус

гомдлыг шийдвэрлэхэд тухайн иргэнээс нэмэлт мэдээлэл, тодруулга авах, Сүхбаатар аймгийн Цагдаагийн газраас мэдээлэл авах зэргээс шалтгаалж нэмэлт хугацаа шаардагдсан.

5. Хугацаа хэтрүүлсэн өргөдлийн тайлбар: Замын-Үүдийн чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанаас Ц.Ганбатын 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр ирүүлсэн ээлжийн амралт олгох тухай хүсэлтийг шийдвэрлэхэд ажлын төлөвлөлтөөс шалтгаалан ээлжийн амралт олгох хугацаа хойшлогдож байсан тул хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн.
6. Хугацаа хэтрүүлсэн өргөдлийн тайлбар: “Хил хязгааргүй алхам” ТББ-аас 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 45/24 дугаартай албан бичгээр “Тавантолгой” бүлэг ордоос Ханги боомт хүртэлх 478 км авто замын төслийг хэрэгжүүлэх үед ачаа тээврийн шороон замууд говийн нэн эмзэг бэлчээрийн хөрсний үржил шимт хэсгийг эргэж сэргэхээргүй болгож байгаагаас гадна, мал амьтан, отор нүүдлийн хөдөлгөөн, орон байртай байх эрхэд ноцтой аюул үүсгэж байгаа тул авто замын чанар шалгах, зам хүлээж авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд “Хил хязгааргүй алхам” ТББ-аас төлөөлөл оролцуулах хүсэлтийг ирүүлсэн байна. Тус хүсэлтийг шийдвэрлэх явцад хууль, эрх зүйн зөвлөгөө авах үйл ажиллагааны мэдээлэлтэй танилцах, нэмэлт тодруулга авах шаардлагатай болсон.

#### **Хугацаа хэтрүүлсэн гомдлын тайлбар: “ Хан шинхуа**

“Юу би метал маркет” ХХК-ийн өмчийн төмрийн үйлдвэрийг түрээслэгч БНХАУ-ын иргэн Хан Шихуагаас 2024 оны 04 дүгээр сард тус компанийн гүйцэтгэх захирал Б.Ууганбаатарт холбогдох залилан, дээрэм, танхайрал байж болзошгүй хэргийн талаар гомдлыг ирүүлсэн. Гомдолд мөрдөн байцаах газар болон хяналтын прокурор нар тус хэргийг үнэн бодитой шалгахгүй байгаа бөгөөд БНХАУ-ын иргэн Хан Шихуа одоог хүртэл хохирсоор байгааг дурдсан байна. Энэ тухай гомдлыг БНХАУ-ын иргэн Хан Шихуа өмнө нь 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр ирүүлсэн бөгөөд Цагдаагийн ерөнхий газраас 2024 оны 03/972 дугаартай албан бичгээр мэдээлэл хүсэхэд Цагдаагийн ерөнхий газраас мөрдөн шалгах ажиллагааны бие даасан байдлыг хангаж ажиллах шаардлагатай тул мэдээлэл одоогоор өгөх боломжгүй байна гэсэн хариуг утсаар өгсөн. БНХАУ-ын иргэн Хан Шихуатай холбоо барьж, тодруулга мэдээлэл хүсэх гээд хүсэлтэд заасан 2 дугаар луу удаа дараа залгасан боловч утсаа аваагүй болно.

Эдийн засаг хөгжлийн яам нь гадаадын хөрөнгө оруулалтын асуудлыг хариуцаж байсан бөгөөд нийт хүлээн авсан гомдлын 66.6 хувийг гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой асуудал, 18.18 хувийг хүний нөөцтэй холбоотой асуудал, 15.15 хувийг бусад асуудал тус тус эзэлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 34 дүгээр хуралдаан, 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 12 дугаар хуралдааны тэмдэглэлд Засгийн газрын гишүүдэд өгсөн үүрэг, даалгаврын дагуу Эдийн засаг, хөгжлийн яаманд ирүүлсэн өргөдөл, гомдлыг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”-ийн 16 дугаар зүйлд заасан хугацаанд шийдвэрлэж байгаа бөгөөд цаашид илүү түргэн шуурхай, иргэдэд хүндрэл чирэгдэлгүй ажиллаж, үйл ажиллагаагаа улам сайжруулахыг зорьж байна.

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ТАЙЛАН

Хугацаа: 2024.01-2024.12.31

1.ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ТӨРӨЛ  
1.1 ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ТАЙЛАН  
/2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/

| Байгууллагын нэр                                                                                                                  | Өргөдөл гомдлын төрөл                                                                                                                                                   |                                                                                                                                 |                                                |                                       |                               | Хүлээн авсан хэлбэр                             |                                           |                                               |               |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------|---------------------------------------|-------------------------------|-------------------------------------------------|-------------------------------------------|-----------------------------------------------|---------------|
|                                                                                                                                   | Мэдэгдэл                                                                                                                                                                | Гомдол                                                                                                                          | Санал                                          | Хүсэлт                                | Биеэр                         | Утсаар                                          | Цахимаар                                  | 11-11 төвөөс шилжүүлсэн                       | Албан бичгээр |
|                                                                                                                                   | 1                                                                                                                                                                       | 2                                                                                                                               | 3                                              | 4                                     | 5                             | 6                                               | 7                                         | 8                                             | 9             |
| Тайлбар:<br><br>Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гарсан хүсэлт | Төрийн байгууллага албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт | Төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан иргэний хүсэлтийг | Дотоод асуудал, үйлчилгээ авах хүсэлтээс бусад | Иргэн өөрийн биеэр ирж, өргөдөл өгсөн | Байгууллагын тусгай дугаараар | Вэб сайт, аппликэйшн, сошиал флатформ, мэйл г.м | 11-11 төвд бүртгэгдэн, цахимаар шилжүүлэн | ААНБ, хуулийн этгэдээс албан бичгээр ирүүлсэн |               |
| Эдийн засаг, хөгжлийн яам                                                                                                         | -                                                                                                                                                                       | 11                                                                                                                              | -                                              | 41                                    | -                             | -                                               | -                                         | 14                                            | 52            |

## 1.2 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭСТЭЙ ХАРЬЦУУЛСАН ДҮН

| Байгууллагын нэр          | Өргөдөл гомдлын төрөл                                                                                             |                                                                                                                                                                         |                                                                                                                              |                                                | Хүлээн авсан хэлбэр                   |                               |                                                  |                                           |                                                |
|---------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------|---------------------------------------|-------------------------------|--------------------------------------------------|-------------------------------------------|------------------------------------------------|
|                           | Мэдэгдэл                                                                                                          | Гомдол                                                                                                                                                                  | Санал                                                                                                                        | Хүсэлт                                         | Биеэр                                 | Утсаар                        | Цахимаар                                         | 11-11 төвөөс шилжүүлсэн                   | Албан бичгээр                                  |
|                           | 1                                                                                                                 | 2                                                                                                                                                                       |                                                                                                                              | 3                                              | 4                                     |                               |                                                  |                                           | 5                                              |
| Тайлбар:                  | Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гарсан хүсэлт | Төрийн байгууллага албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт | Төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан иргэний хүсэлт | Дотоод асуудал, үйлчилгээ авах хүсэлтээс бусад | Иргэн өөрийн биеэр ирж, өргөдөл өгсөн | Байгууллагын тусгай дугаараар | Вэб сайт, аппликэйшн , сошиал флатформ, мэйл г.м | 11-11 төвд бүртгэгдэн, цахимаар шилжүүлэн | ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн |
| Эдийн засаг, хөгжлийн яам | -                                                                                                                 | 27                                                                                                                                                                      | 3                                                                                                                            | 58                                             |                                       |                               |                                                  | 31                                        | 88                                             |

2. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ  
2.1 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР

| Шийдвэрлэлтийн байдал         |          |        |         |                                 |                                             |                                           |                                                                 |                  |                      |
|-------------------------------|----------|--------|---------|---------------------------------|---------------------------------------------|-------------------------------------------|-----------------------------------------------------------------|------------------|----------------------|
| Шийдвэрлэж хариу өгсөн байдал |          |        |         | Бусад байгууллагад шилжүүлсэн   |                                             | Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /30 хоног/ | Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /60 хоног/ | Хугацаа болоогүй | Шийдвэрлэх боломжгүй |
| Албан бичгээр                 | Цахимаар | Утсаар | Биечлэн | Харьяаллын дагуу шилжүүлсэн тоо | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо |                                           |                                                                 |                  |                      |
| 35                            | 14       | 6      | 11      | -                               | -                                           | 6                                         | 1                                                               | -                | -                    |

2.2 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭСТЭЙ ХАРЬЦУУЛСАН ДҮН

| Шийдвэрлэлтийн байдал         |          |        |         |                                 |                                             |                                           |                                                                 |                  |                      |
|-------------------------------|----------|--------|---------|---------------------------------|---------------------------------------------|-------------------------------------------|-----------------------------------------------------------------|------------------|----------------------|
| Шийдвэрлэж хариу өгсөн байдал |          |        |         | Бусад байгууллагад шилжүүлсэн   |                                             | Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /30 хоног/ | Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /60 хоног/ | Хугацаа болоогүй | Шийдвэрлэх боломжгүй |
| Албан бичгээр                 | Цахимаар | Утсаар | Биечлэн | Харьяаллын дагуу шилжүүлсэн тоо | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо |                                           |                                                                 |                  |                      |
| 88                            | -        | 3      | 4       | 2                               | -                                           | 6                                         | -                                                               | 3                | -                    |

## 3. Агуулгын дүн шинжилгээ

| Гомдлын агуулга                                                 | Тоо | Хувь  | Гомдлыг бууруулахад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал                                                     |
|-----------------------------------------------------------------|-----|-------|-----------------------------------------------------------------------------------------------------------------|
| Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаатай холбоотой | 44  | 66.6% | Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулах, хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулах |
| Хүний нөөцтэй холбоотой                                         | 12  | 18.1% | Төрийн жинхэнэ албан тушаалд орох, нөөцөд бүртгүүлэх                                                            |
| Бусад                                                           | 10  | 15.1% | Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх                                                                     |

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ БОЛОН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДАД 2024 ОНД  
ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТЭД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах, хуулийн хугацаанд багтаан шийдвэрлүүлэх, байгууллагын үйл ажиллагаа, хариуцлагыг дээшлүүлэхэд удирдлага болон хэрэглэгчийг шаардлагатай мэдээллээр хангахад оршино.

Хоёр. Арга зүй

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 2005 оны 67 дугаар тогтоолын хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яаманд 2024 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс төрийн байгууллага болон албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1-т заасан аргачлалаар үнэлсэн.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Эдийн засаг, хөгжлийн яам болон харьяа байгууллагуудад 2024 оны жилийн эцэст нийт 11 гомдол, 41 хүсэлт бичиг хэргээр дамжин байгууллагын албан бичиг хөтлөлтийн программд бүртгэгдэж, Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөс 14 санал, нийт 66 санал, гомдол, өргөдөл шилжиж ирсэн байна.

Хүснэгт 1. Өргөдөл, гомдлыг хүлээн авсан хэлбэрээр авч үзвэл:

| Д/д  | Өргөдөл, гомдол хүлээн авсан хэлбэр | Тоо | Эзлэх хувь |
|------|-------------------------------------|-----|------------|
| 1    | Биеэр                               | -   | -          |
| 2    | Утсаар                              | -   | -          |
| 3    | Цахимаар                            | -   | -          |
| 4    | 11-11 төвөөс шилжүүлсэн             | 14  | 21.2 %     |
| 5    | Албан бичгээр                       | 52  | 78.8 %     |
| Нийт |                                     | 66  | 100 %      |

2024 онд эдийн засаг хөгжлийн яаманд хандаж иргэдээс ирүүлсэн 11 гомдол, 14 санал, 41 хүсэлт нийт 66 өргөдөл гомдол, хүсэлт байна.



Хүснэгт 2. Ирүүлсэн өргөдөл, гомдлыг төрлөөр нь нэгтгэн харуулбал:

| Байгууллагын нэр          | Өргөдөл, гомдлын төрөл |        |       |        | Нийт дүн | Нийт дүнд эзлэх хувь |
|---------------------------|------------------------|--------|-------|--------|----------|----------------------|
|                           | Мэдэгдэл               | Гомдол | Санал | Хүсэлт |          |                      |
|                           | 1                      | 2      | 3     | 4      | 5        | 6                    |
| Эдийн засаг, хөгжлийн яам | -                      | 11     | 14    | 41     | 66       | 100%                 |

Нийт өргөдөл гомдлын 16,6 хувийг гомдол, 21,2 хувийг санал, 62,1 хувийг хүсэлт эзэлж байна.

Эдийн засаг, хөгжлийн яам болон харьяа байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс албан бичгээр ирүүлсэн нийт 66 өргөдөл, гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 59 өргөдөл гомдлыг хугацаанд нь, 6 гомдлыг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт зааснаар 30 /гуч/ хоногийн хугацааг хэтрүүлэн шийдвэрлэж, 1 гомдол сунгалт хийсэн боловч хугацаа хэтэрч шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 3. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

| Д/д | Өргөдөл гомдлын шийдвэрлэлт                     | Өргөдөл, санал гомдлын тоо | Эзлэх хувь   |
|-----|-------------------------------------------------|----------------------------|--------------|
| 1   | Хугацаандаа шийдсэн                             | 59                         | 89.4 %       |
| 2   | Хугацаа хэтрүүлэн шийдсэн                       | 6                          | 9.1 %        |
| 3   | Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдсэн | 1                          | 1.5 %        |
|     | <b>НИЙТ</b>                                     | <b>66</b>                  | <b>100 %</b> |

Дээрх хүснэгтээс харахад өргөдөл гомдлын шийдвэрлэлт 98.5 хувийн үзүүлэлттэй байна

Хугацаа хоцорч шийдвэрлэгдсэн өргөдөл, гомдлын тайлбар:

“Жин и жао” ХХК-ийн Ерөнхий захирал Ц.Ганболдод Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2013 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 1068 дугаар шүүхийн шийдвэрээр түүнд Засгийн газрын нөөц хөрөнгөөс 427,494,661 төгрөгийг гаргуулан олгуулахаар шийдвэрлэснийг хүчингүй болгосонд 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01/06 дугаар албан бичгээр гаргасан гомдлыг шийдвэрлэх явцад хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны мэдээлэлтэй танилцах, нэмэлт тодруулга авах шаардлага гарсан байна.

Иргэн Н.Алтангэрэлээс 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдөр ирүүлсэн Шүүхийн барилга, байгууламж тэдгээрийн нөхцөлийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлэл хүссэн хүсэлт нь Монгол Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний саналыг судалж шийдвэрлэх хугацаанд ирүүлсэн, шүүхийн барилга байгууламжийн ажиллах, нөхцөл боломж шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг цуглуулахад нэмэлт хугацаа шаардлагатай болсон байна.

Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн ХЭГ/339 дугаартай албан бичгээр Канад Улсын иргэн Даниел Бодуэний хувь хүний нууцад хамаарах мэдээллийг Гадаад харилцааны яамны Консулын газрын дэд захирал Ч.Батбилэг бусдад дамжуулсан тухай итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Адъяасүрэнгийн гаргасан гомдол нь цагдаагийн газар дээр хянагдаж байсан бөгөөд, хэрхэн шийдвэрлэх талаар судалгаа хийж, удирдлагатай зөвшилцөхөд хугацаа шаардагдсан байна.

БНХАУ-ын иргэн И.Цогт /Chaoketu/ 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр “ЭБНЭ” ХХК-ийн хувьцаа эзэмшигч бөгөөд гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Д.Эрдэнийн залилангийн хэргийг мөрдөн шалгах ажиллагаа удаашралтай байгаа болон Ашигт малтмалын тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчээр бүртгээгүй байгаа тухай гомдлыг шийдвэрлэхэд тухайн иргэнээс нэмэлт мэдээлэл, тодруулга авах, Сүхбаатар аймгийн Цагдаагийн газраас мэдээлэл авах зэргээс шалтгаалж нэмэлт хугацаа шаардагдсан байна.

Замын-Үүдийн чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанаас Ц.Ганбатын 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр ирүүлсэн ээлжийн амралт олгох тухай хүсэлтийг шийдвэрлэхэд ажлын төлөвлөлтөөс шалтгаалан ээлжийн амралт олгох хугацаа хойшлогдож байсан тул хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн байна.

“Хил хязгааргүй алхам” ТББ-аас 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 45/24 дугаартай албан бичгээр “Тавантолгой” бүлэг ордоос Ханги боомт хүртэлх 478 км авто замын төслийг хэрэгжүүлэх үед ачаа тээврийн шороон замууд говийн нэн эмзэг бэлчээрийн хөрсний үржил шимт хэсгийг эргэж сэргэхээргүй болгож байгаагаас гадна, мал амьтан, отор нүүдлийн хөдөлгөөн, орон байртай байх эрхэд ноцтой аюул үүсгэж байгаа тул авто замын чанар шалгах, зам хүлээж авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд “Хил хязгааргүй алхам” ТББ-аас төлөөлөл оролцуулах хүсэлт ирүүлсэн гомдлыг шийдвэрлэх явцад хууль, эрх зүйн зөвлөгөө авах үйл ажиллагааны мэдээлэлтэй танилцах, нэмэлт тодруулга авах шаардлагатай болсон.

Хугацаа хэтрүүлсэн гомдлын тайлбар: “Хан шинхуа

“Юу би метал маркет” ХХК-ийн өмчийн төмрийн үйлдвэрийг түрээслэгч БНХАУ-ын иргэн Хан Шихуагаас 2024 оны 04 дүгээр сард тус компанийн гүйцэтгэх захирал Б.Ууганбаатарт холбогдох залилан, дээрэм, танхайрал байж болзошгүй хэргийн талаар гомдлыг ирүүлсэн. Гомдолд мөрдөн байцаах газар болон хяналтын прокурор нар тус хэргийг үнэн бодитой шалгахгүй байгаа бөгөөд БНХАУ-ын иргэн Хан Шихуа одоог хүртэл хохирсоор байгааг дурдсан байна. Энэ тухай гомдлыг БНХАУ-ын иргэн Хан Шихуа өмнө нь 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр ирүүлсэн бөгөөд Цагдаагийн ерөнхий газраас 2024 оны 03/972 дугаартай албан бичгээр мэдээлэл хүсэхэд Цагдаагийн ерөнхий газраас мөрдөн шалгах ажиллагааны бие даасан байдлыг хангаж ажиллах шаардлагатай тул мэдээлэл одоогоор өгөх боломжгүй байна гэсэн хариуг утсаар өгсөн. БНХАУ-ын иргэн Хан Шихуатай холбоо барьж, тодруулга мэдээлэл хүсэх гээд хүсэлтэд заасан 2 дугаар луу удаа дараа залгасан боловч утсаа аваагүй байна.

Хүснэгт 2. Албан бичгээр ирүүлсэн өргөдөл, гомдлыг агуулгаар нь задалж үзвэл:

*Хүснэгт 4. Өргөдөл, гомдол агуулгаар*

| дд | Өргөдөл, гомдлын агуулга                                        | Тоо       | Хувь           |
|----|-----------------------------------------------------------------|-----------|----------------|
| 1  | Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаатай холбоотой | 44        | 66.6 %         |
| 2  | Хүний нөөцтэй холбоотой                                         | 12        | 18.2 %         |
| 3  | Бусад                                                           | 10        | 15.2 %         |
|    | <b>Нийт</b>                                                     | <b>66</b> | <b>100.0 %</b> |

Нийт ирсэн өргөдөл гомдлын 66,6 хувийг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаатай холбоотой, 18.2 хувийг хүний нөөцтэй, 15.2 хувийг эзэлж байна.

*Хүснэгт 5. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг өмнөх онтой харьцуулж үзвэл*

| д/д | Өргөдөл гомдлын төрөл | 2023 он   | 2024 он   | Өсөлт бууралт хувиар |
|-----|-----------------------|-----------|-----------|----------------------|
| 1   | Мэдэгдэл              | 2         | 11        | 32.7 %               |
| 2   | Гомдол                | 30        | 14        |                      |
| 3   | Санал                 | 5         | 41        |                      |
| 4   | Хүсэлт                | 61        | -         |                      |
|     | <b>Нийт</b>           | <b>98</b> | <b>66</b> |                      |

Өргөдөл, гомдол, хүсэлт шийдвэрлэлт өмнөх оноос 32.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

*Дөрөв. Дүгнэлт*

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-т “Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг тухайн байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно. Хугацаа сунгасан тухай өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ.” гэж заасан бөгөөд тус хуулийн дагуу тайлант хугацаанд нийт 66 өргөдөл, гомдлын 59 нь хугацаандаа шийдвэрлэгдсэн, 6 нь хугацаа хэтэрсэн бөгөөд өргөдөл, гомдол шийдвэрлэлт 98.5 хувьтай байна. “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3-д заасан ангилалд шилжүүлэн тооцвол өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн байдал “үр дүнтэй” гэж үнэлэгдлээ.

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР**